НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ДАВААНЯМ ТАНАА

2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр №1 Улаанбаатар хот

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН САНАЛ

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын даргын 2023 оны А/98 дугаар тушаалаар байгуулагдсан албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий "Үнэлгээний баг" нь Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн дараах САНАЛ-ыг гаргав.

Нэг. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр "Маш сайн" (85-100 оноо) үнэлгээний ангилалд эрэмбэлэгдсэн 14 албан хаагчдад Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.6.1.б-д заасны дагуу *мөнгөн урамшуулал олгох*;

Хоёр. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр "Маш сайн" (85-100 оноо) үнэлгээний ангилалд эрэмбэлэгдсэн албан хаагчдад олгох мөнгөн урамшуллын хэмжээг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т нийцүүлж, III болон IV улирлын урамшуллыг тус бүр үндсэн цалингийн 50 хувиар тооцох;

Гурав. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр "Хэвийн" (70-85 оноо) үнэлгээний ангилалд эрэмбэлэгдсэн 3 албан хаагчдад Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.6.1.в-д заасны дагуу *мөнгөн урамшуулал олгох*;

Дөрөв. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр "Хэвийн" (70-85 оноо) үнэлгээний ангилалд эрэмбэлэгдсэн албан хаагчдад олгох мөнгөн урамшуллын хэмжээг "Маш сайн" ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуллын 50 хувиар буюу III болон IV улирлын урамшуллыг тус бүр үндсэн цалингийн 25 хувиар тооцон олгох зэрэг болно.

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН АХЛАГЧ: ..... М.НАМХАЙРИНЧЭН

ГИШҮҮД: ..... Д.САЙНХҮҮ

..... Б.ЧОЙЖИЛСҮРЭН

..... Ц.БАТНАВЧ

..... Г.ЭНХЗУЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: ..... Б.ОРХОНБАЙГАЛЬ